



Шүүхийн ахмадуудын холбоо

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
2018 оны 12 дугаар сарын 21-ний
өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН АХМАДЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн Ахмадын сан (цаашид "сан" гэнэ)-ийн хөрөнгийг бурдуулэх, зарцуулах, тайлгахаа, хяналт тавих харилцааг энэ журмаар зохицуулна.

УХА0052 1701517

1.2. Шүүхийн тухай багц хууль, Төсвийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Ахмадын сан байгуулан ажиллуулах журам, бусад хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.

1.3. Сан өөрийн данстай байна.

Хоёр. Сангийн хөрөнгийн бурдуулэлт

2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бурдуулна:

2.1.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухайн жилийн төлөвлөгөөнөөс давсан орлогын 10 хүртэл хувь болон цалингийн нийт сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр санд төвлөрүүлсан хөрөнгө;

2.1.2. Сангийн үйл ажиллагаанаас олох орлого;

2.1.3. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;

2.1.4. Гадаад, дотоодын байгууллага болон иргэдээс санд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламж;

2.1.5. Сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого;

2.1.6. Бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6-д заасан дараах арга хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулна:

3.1.1. Шүүхийн байгууллагад онцгой үр бүтээл гарган олон жил идэвхи зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэмж олгох;

3.1.2. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулах;

3.1.3. Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад нь зориулан жил бүр Засгийн газраас тогтоосон хэмжээгээр мөнгөн дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;

3.1.6. Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх;



3.1.7. Ахмад настан өөрөө эсхүл түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;

3.1.8. Ахмадуудын дунд идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.9. Амьжирааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай болон харж хандах ах дүү, төрөл садангуй, ганц бие ахмад настанд мөнгөн тусламж олгох;

3.2. Энэхүү журмын 3.1.2, 3.1.8-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээг хөдөлмөрийн хөлслийн доод хэмжээний 20 хувиас багагүй байхаар тогтоож, байгууллагын төсөв болон дотоод журам, ажилтнуудын нийгмийн хамгааллын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

3.3. Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно.

3.4. Сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт болон бусад шаардлагатай холбогдох баримт бичгийг бүрдүүлэн харьяа Ахмадын салбар зөвлөлөөрөө уламжлуулан Шүүхийн ахмадуудын холбоонд хүсэлт гаргана.

3.5. Шүүхийн ахмадуудын холбооны албан ёсны саналыг үндэслэн хүсэлтийг шийдвэрлэнэ.

3.6. Шүүхийн ерөнхий зөвлөл өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд сангийн хөрөнгийг ахмадуудын бүртгэлийн хамт тухайн байгууллагын эрх, үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдэд шилжүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад аудит холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

4.2. Ахмад настанд нэмэгдэл тэтгэмж, тусламж, дэмжлэг олгох, сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба болон Шүүхийн Ахмадуудын холбоо хамтран хариуцан гүйцэтгэнэ.

4.3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Шүүхийн Ахмадуудын холбоонд ирүүлнэ.



Шүүхийн ахмадуудын холбоо



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр

№ 58/2018-09 Улаанбаатар хот

Шүүхийн өрөнхий зөвлөлийг төлөөлж Гүйцэтгэх нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар, Шүүхийн ахмадуудын холбоог төлөөлж дэд тэргүүн С.Бямбаа нар Монгол улсын Иргэний хууль, Ахмад настны тухай хуулийн холбогдох заалтын дагуу дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэ гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1. Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд ахмад шүүгч, ажилтны оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг, туршлагаа хойч үедээ өвлүүлэх, сургалт зохион байгуулах, шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шүүхийн эрх зүйг олон нийтэд сурталчлах ажлыг хамтран болон дангаар зохион байгуулах

Хоёр. Талуудын эрх, үүрэг

А. Шүүхийн өрөнхий зөвлөлийн эрх, үүрэг

2.1 Ахмад шүүгч, ажилтныг хууль тогтоомж боловсруулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх ажилд оролцуулах арга хэмжээ авах,

2.2. Тэдний нийгмийн оролцоо, хэгжил, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих,

2.3. Үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай байр, ширээ сандал, техник тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх,

2.4. Шүүхийн сургалтад сургач багшаар ажиллаж, мэдлэг туршлагаа залуу шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд зааж сургах боломжийг олгох.

2.5 Холбооны бүх гишүүдийн болон удирдах зөвлөлийн хуралдаан явуулах бэлтгэлийг хангах, шаардагдах дүрэм, журмуудыг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх



2.6 Шүүхийн ерөнхий зөвлөл Ахмадуудын холбооны гэрээнд заасан үйл ажиллагааны зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Б.Ахмадуудын холбооны эрх, үүрэг

2.7 Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд үнэн зөв, төв голч мэдээлэл өгэх,

2.8 Шинэ залуу шүүгч, ажилтнуудад мэдлэг, туршлагаа хуваалцах, сургалт зохион байгуулах, шүүгч хараат бус байх, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх,

2.9 Шүүхийн хараат бус байдлыг хангаж, хамгаалахад хувь нэмэр оруулах,

2.10 Ахмад шүүгч, ажилтны эрх ашгийг хамгаалах, сайн дурын болон бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах,

2.11 Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны газар, хэлтсүүдтэй хамтран ажиллах,

2.12 Ахмадуудын холбоо болон гишүүд идэвх санаачилгатай ажиллаж, улирал тутам хийсэн ажлаа тайлагнах.

Гурав. Гэрээ хүчин төгөлдөр болох, гэрээний хугацаа

3.1 Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээг дуусгавар болгох талаар аль нэг талаас бичгээр хүсэлт гаргаагүй бол гэрээг сунгагдсанд тооцно.

3.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар талуудын аль нэг нь санал гаргаснаар тухай бүр шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1 Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан бөгөөд гэрээг биелүүлэх, гэрээг тайлбарлахад Монгол Улсын хуулийг баримтална. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.2 Талууд гэрээний үүргээ биелүүлэхийн тулд санаачилгатай ажиллана. Гэрээний ямар нэгэн маргаан үүсвэл талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4.3 Талууд энэхүү гэрээг Монгол хэлээр адил хүчинтэй 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгална.



Шүүхийн ахмадуудын холбоо

4.4 Гэрээний Хавсралтууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь энэ гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний адил хүчинтэй байна.

Гэрээг хянасан:

Хууль зүйн асуудал хариуцсан референт... Г.Энхтуяа

Гэрээ байгуулсан:

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙГ
ТӨЛӨӨЛЖ:
ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА О.АМГАЛАНБААТАР

ШҮҮХИЙН АХМАДУУДЫН
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:
ДЭД ТЭРГҮҮН С.БЯМБАА